



**ЗАВХАН АЙМГИЙН
САНХҮҮГИЙН ХЯНАЛТ, АУДИТЫН АЛБА
ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ТАНИЛЦУУЛГА**

2022 оны 04 сарын 11 өдөр

Дугаар 06

Улиастай

**ДОТООД АУДИТ ХИЙСЭН АЖЛЫН
ТОВЧ ТАЙЛАН**

Албаны 2022 ажлын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Улиастай сумын Хүүхдийн 2-р цэцэрлэгийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 03 дугаар удирдамжаар дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтыг хийв.

Аудит, хяналт шалгалтын ажлын багийн бүрэлдэхүүн

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны

ДА-СХШУАБ Б.Батхүү

ДА-СХШУБ Т.Цэрэндолгор

Хүүхдийн хоолны зардлын зарцуулалт, бүртгэл, хяналт

2020 онд 66 хоног хичээллэж 11784 хүүхдэд 24037406 төгрөг, 2021 онд 100 хоног хичээллэж 9075 хүүхдэд 22500000 төгрөгийн хоолны зардал гарсан. Аймгийн онцгой комисс болон БСУГ-ын даргын шийдвэрээр 2020 онд зорилтот бүлгийн 15 хүүхдэд 1076910 төгрөгийн хоолны материал олгосон. 2021 онд өндөржүүлсэн бэлэн байдлын үед пост, штабт ажиллаж байсан 505 хүнд 3878450 төгрөгийн хоол, вакцинжуулалтанд ажилласан багийн эмч, ажилчдын хоолны зардалд 15 хүнд 195250 төгрөгийн хоол өгсөн байна /пост, вакцинжуулалтанд ажиллах, ажилласан хүмүүсийн тоо болон нэг хүнд ногдох хоолны зардлыг баталсан шийдвэр байхгүй/.

АУДИТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, АУДИТЫН ҮР ДҮН

Илэрсэн асуудал 1	Шийдвэргүйгээр ур чадварын нэмэгдэл авсан
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: Эрхлэгчид эрх бүхий албан тушаалтны шийдвэргүйгээр 723,6 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл, мэргэшлийн зэргийг давхардуулан 192,9 мянган төгрөгийг олгосон. Нягтлан бодогч үр дүнгийн урамшууллыг хавсран гүйцэтгэж байгаа байгууллагаас давхардуулан авсан	
Байх ёстой шаардлага / шалгуур/: ЗГ-ын 2018 оны 382 тогтоол, ЗГ-ын 2019 оны 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт	
Асуудлын үндсэн шалтгаан: Дотоод хяналтын нэгж хяналт тавиагүй	
Байгууллагад үзүүлэх нөлөө / үр дагавар/: Төсвийн зардлыг үрэлгэн зарцуулсан	
Зөвлөмж: Засгийн газрын 382-р тогтоолыг хэрэгжүүлэх, Төсвийн тухай хуулийн 6.4.1	

дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах

Илэрсэн асуудал 2	Хүүхдийн тоог өсгөн хоолны зардлыг илүү тооцсон
Асуудлын ангилал	Нөлөө ихтэй
Бодит байдал: хүүхдийн тоог өсгөн хоолны зардлыг илүү тооцож олгосон.	
Байх ёстой шаардлага / шалгуур/: ЗГ-ын 2019 оны 450 тогтоолыг мөрдөн ажиллах,	
Асуудлын үндсэн шалтгаан: Багш нарын хүүхдийн ирц, няравын ордер дээрх ирцийг тулгаагүй Эрхлэгч, нягтлан бодогчийн хяналт сул, Дотоод хяналтын нэгж хангалтгүй ажилласан	
Байгууллагад үзүүлэх нөлөө / үр дагавар/: Хүүхдийн хоолны зардал үрэлгэн зарцуулагдана, хоолны төсөв хүрэлцээгүй болох магадлалтай,	
Зөвлөмж: Төсвийн тухай хуулийн 6.4.1 дэх заалтыг хэрэгжүүлж ажиллах	

ДҮГНЭЛТ:

Тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаа, баримтын бүрдэлт, тайлагналт нь НББОУС-ын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн боловч "Төсвийн тухай", "Нягтлан бодох бүргэлийн тухай" Засгийн газрын 2018 оны 382 дугаар, 2019 оны 5 дугаар тогтоолын хэрэгжилт "Хангалтгүй" байна.

Цаашид хийх ажлын талаарх зөвлөмж

1. Санхүүгийн үйл ажиллагааны эрсдэл, төсөл хөтөлбөр, хүүхдийн хоолны материал худалдан авахад гарч болох эрсдэлийн үнэлгээ хийж урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах.
2. Дотоод хяналтын нэгжийн үйл ажиллагааг төсөл хөтөлбөр, худалдан авалтын зардлуудад чиглүүлэн хяналт шалгалт хийх
3. Хүүхдийн хоолны материалыг тендерт шалгарсан газраас гэрээ байгуулан худалдан авдаг байх
4. Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар батлагдсан "Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар"-ын дагуу төсвийг зарцуулах
5. Актын төлбөрийг тогтоосон хугацаанд барагдуулж хураан барагдуулалтын тайланг ирүүлэх.

ТАЙЛАН БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДА-СХШУБ Т.ЦЭРЭНДОЛГОР

